



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 0/608

Улаанбаатар хот

Налайх дүүргийн Эрүүл Мэндийн  
төвийн данс бүртгэлд  
хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 9,738,216.0 /есөн сая долоон зуун гучин найман мянга хоёр зуун арван зургаан/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв /Л.Байгал/-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв /Л.Байгал/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

~~ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ~~

Ш.ҮНЭНБАТ

115053001679

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
 газрын даргын 2019 оны ... дугаар  
 сарын ... өдрийн ... тоот тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ /төгрөгөөр/		Хөрөнгө оруулалт	
									Нэг бүрийн үнэ	Нийт дүн	Нэр	Эх үүсвэр
1	Дүрс дамжуулагч камер	Avililon	2.0C-H4PTZ-DP30	2019	2019	сайн	ш	1	4,117,879	4,117,879	НҮБ-ын хүн амын сан	Хандив
2	Суурин компьютер	Dell	I-5	2019	2019	дунд	ш	1	310,823	310,823		
3	Телефон аппарат	Planet	Дуу цацагчтай vpr-8030NT HD	2019	2019	дунд	ш	1	2,690,314	2,690,314		
									1,069,200	1,069,200		
<b>Тавилга эд хогшлын дүн</b>										<b>8,188,216</b>		
4	Дугуйтай насилка	Шаргал	эвхэгддэг	2019	2019	сайн	ш	1	150,000	1,200,000	Баянгол мед ХХК	
5	Суугаа тэргэнцэр	Хар		2013	2019	дунд	ш	1	600,000	350,000		
<b>Тоног төхөөрөмжийн дүн</b>										<b>1,550,000</b>		
<b>Нийт бүртгэх дүн</b>										<b>9,738,216</b>		